



1	Бүтээлийн нэр	Хэнтийн нүүрсний уурхайн хөрс хуулалтын хаягдал шаврыг ашиглан Барилгын эмульс гарган авах судалгааны ажил
2	Байгууллагын нэр	ШУТИС-БАС-ББЭТ –ийн 3-р курсын оюутнууд
3	Зохиогчийн нэр	Ч.Жанчив , С.Пүрэвжаргал , Д.Пүрэвдорж, М.Батбаяр Удирдсан багш: Д.Сүнжидмаа /Ph.D Дэд профессор/
4	Бүтээлийн товч танилцуулга	Уул уурхайн хаягдал шавар ашиглан өргөн хэрэглээний барилгын материал болох барилгын эмульс үйлдвэрлэх жор найрлага, технологийг боловсруулж, барилгын үйлдвэрлэлд хаягдалгүй, ЭКО технологийг бий болгосон бөгөөд бидний санал болгож буй бүтээгдэхүүн нь усан суурьтай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй эмульсэн будаг.
5	Хэрэглээний хүрээ зориулалт	Бүх төрлийн барилга байгууламжийн дотор хананд.
6	Онцлог давуу тал	<ul style="list-style-type: none"> • Технологийн хувьд энгийн • Эдийн засагт үр ашигтай • Хаягдал ашигласан ЭКО технологи • Улс орны тогтвортой хөгжилд тодорхой нөлөөллийг үзүүлнэ. • Импортын бүтээгдэхүүнийг орлоно.
7	Техник үзүүлэлт	Монгол улсын стандарт (MNS52.52.2003) дагуу BA27 төрлийн эмульсэн будгийн шаардлагыг хангана.
8	Үр дүн ба дүгнэлт	Эмульсэн будаг нь Ус-45%, Шавар-10%, Шохой-12%, Цавуу-9% бусад нэмэлтийг агуулсан хольцоос тогтоно. Хаягдал шавар нь голчлон хээрийн жонш, кварцаас тогтсон цайвар шаргал өнгийн шавар болно. Хэнтий аймгийн нүүрсний уурхайн хаягдал шаврыг ашиглан барилгын эмульс үйлдвэрлэх боломжтой технологийг Монголд анх удаа боловсруулсан. Энэ шаврыг ашиглан гарган авсан эмульсэн будаг нь Монгол улсын стандарт (MNS52.52.2003) дагуу BA27 төрлийн эмульсэн будгийн шаардлагыг хангана.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Аваагүй 
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд бэлэн, жор найрлага, технологийг боловсруулсан.

Автомат зам дээр зураг авагч Ногоон эрчим хүч" Эрдэм шинжилгээний бага хурлын бүтээлийн төрөлд ДЭД байр эзэлсэн.


1	Бүтээлийн нэр	Автомат зам дээр зураг авагч, /Timelapse controller slider/
2	Сургуулийн нэр	ШУТИС- Эрчим Хүчний Сургууль ЦЭЗ
3	Зохиогчдын нэр, утас	П.Хангайхүү, 99686016
4	Бүтээлийн товч танилцуулга	Мотор камер хоёр харилцан уялдаатай ажиллаж тодорхой зам дээр авсан бүх зургийг нийлүүлж видео дүрс, контент гарган авах зорилготой юм.
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	ТВ болон кино клип, студи, мултимедиа чиглэлээр үйлж ажиллагаа явуулдаг бүх төрлийн байгуулагад
6	Онцлог давуу тал	Үнэ өртөг 2, 3 дахин хямд туссан
7	Техник үзүүлэлт	Raspberry Pi B+, Touchscreen дэлгэц
8	Үр дүн ба дүгнэлт	Мотор болоод зураг хоорондын зайг хүссэнээрэй удирдах нь давуу тал болсон
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Зохиогчийн эрхийн патент аваагүй.
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Үйлдвэрлэлд нэвтрүүлээгүй.
11	Гаргасан шийдэл	Raspberry Pi хавтанг программчилаж камер болоод моторыг харилцан уялдаатай ажилуулсан. Touchscreen дэлгэцний тусламжтайгаар гаднаас утга оруулах боломж хямбар болж өгсөн.
12	Схем зураг	<p>The diagram illustrates the electrical connections for the timelapse controller. A Raspberry Pi+ is connected to a motor controller via GPIO18 and GPIO27. The motor controller is connected to a 12V battery and a motor. The 12V battery is connected to the motor controller. The 5V battery is connected to the Raspberry Pi+. The camera is connected to the Raspberry Pi+ via a shutter button and an NPN transistor.</p>
		<p>The photograph shows the physical implementation of the circuit. A Raspberry Pi is connected to a motor controller, which is connected to a 12V battery and a motor. A 5V battery is connected to the Raspberry Pi. A camera is connected to the Raspberry Pi via a shutter button and an NPN transistor.</p>

1	Бүтээлийн нэр	Хос дугуйт өөрөө тэнцвэржигч робот
2	Сургуулийн нэр	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Механик, Тээврийн сургууль
3	Зохиогчдын нэр, утас	Ү.Цэнд-Аюуш 99303102
4	Бүтээлийн товч танилцуулга	<i>Хос дугуйт өөрөө тэнцвэржигч роботын механик хийц, кинематик, динамик тооцоон дээр үндэслэн роботын хөдөлгүүр болон тэнцвэржилтийг удирдах алгоритмийг боловсруулсан.</i>
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	Ойрийн болон дунд хэмжээний зайд тээвэрлэлт хийх, үйлдвэрлэл болон олон нийтийн газарт
6	Онцлог давуу тал	Энерги хэмнэн, орон зай бага эзэлдэг
7	Техник үзүүлэлт	Өндөр:20cm өргөн:17.7cm жин:1050гр
8	Үр дүн ба дүгнэлт	Туршилтаар роботын тэнцвэрийг олж биетийг бүрэн тэнцвэржүүлсэн нь дараа дараагийн тэнцвэржилтийн тухай онол практикийн мэдлэгийг бусдад түгээх боломжтой болсон.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Байхгүй
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Байхгүй
11	Гаргасан шийдэл	Үйлдвэр болон үйлчилгээний орчинд овор хэмжээ, орон зай бага эзлэх, энерги бага зарцуулах механизмийг бий болгох.
12	Схем зураг	


1	<i>Бүтээлийн нэр</i>	Хөлдөөх тавцангийн туршилт судалгаа										
2	<i>Сургуулийн нэр</i>	ШУТИС, ҮТС										
3	<i>Зохиогчдын нэр, утас</i>	Т.Намсрай, Г.Тэнгис, док (Ph.D) Ш.Энх-Амгалан										
4	<i>Бүтээлийн товч танилцуулга</i>	Дулааны хоолойн ажиллах зарчимд үндэслэсэн хөргөх бодисоор цэнэглэсэн, цахилгаанаас үл хамааралтай бие даасан хэрэгсэл.										
5	<i>Хэрэглээний хүрээ, зориулалт</i>	Бууз, банш, ширхэгийн хүнсний бүтээгдэхүүнийг хурдан хөлдөөх зориулалттай тавцан.										
6	<i>Онцлог давуу тал</i>	Цахилгаан хэрэглэхгүй, хөлдөөлтийн хурдыг нэмэгдүүлэх, механик хэрэгсэлгүй, олон талын зориулалтаар ашиглаж болно.										
7	<i>Техник үзүүлэлт</i>	<p style="text-align: center;">Хөлдөөх тавцангийн техникийн үзүүлэлт</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 20%;">Дулааны хоолойн төрөл</th> <th style="width: 20%;">Ажлын температурын хязгаар</th> <th style="width: 15%;">Ажлын шингэн</th> <th style="width: 15%;">Хоолойн материал</th> <th style="width: 30%;">Хоолойн чадал, Вт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нам температурын дулаан хоолой</td> <td>-20⁰С...+60⁰С</td> <td>R600a</td> <td>Хөнгөн цагаан</td> <td>15,36</td> </tr> </tbody> </table>	Дулааны хоолойн төрөл	Ажлын температурын хязгаар	Ажлын шингэн	Хоолойн материал	Хоолойн чадал, Вт	Нам температурын дулаан хоолой	-20 ⁰ С...+60 ⁰ С	R600a	Хөнгөн цагаан	15,36
Дулааны хоолойн төрөл	Ажлын температурын хязгаар	Ажлын шингэн	Хоолойн материал	Хоолойн чадал, Вт								
Нам температурын дулаан хоолой	-20 ⁰ С...+60 ⁰ С	R600a	Хөнгөн цагаан	15,36								
8	<i>Үр дүн ба дүгнэлт</i>	<ol style="list-style-type: none"> 1. Хөлдөөх тавцанг дулааны хоолойн ажиллах зарчимд үндэслэн хийж болох нь харагдаж байна. 2. Хөлдөөх тавцангийн гадаргуугийн температур 5⁰С-ээр камерын болон сараалжин тавцангийн температураас бага байна. Энэ нь дулаан дамжуулалтын идэвхийг нэмэгдүүлж, хөлдөөлтийн процессын үр дүнг нэмэгдүүлж байна. 3. Дулааны хоолойн зарчмаар ажилладаг хөлдөөх тавцан нь ус хөлдөөлтийн хугацааг 2,2 дахин бууруулж өгч байна. 										
9	<i>Патент зохиогчийн эрх авсан байдал</i>	<p>Патент оновчтой бүтээл:</p> <ol style="list-style-type: none"> 1.2005 он 11-р сарын 10. Ашигтай загварын гэрчилгээ. №4311. Хүйтэн хуримтлуулагчтай зoorь. 2. 2006 он 07-18. Ашигтай загварын гэрчилгээ .№ 1443. Хөргөлтийн хоолой хийх ашиглах аргачлал. 										
10	<i>Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал</i>	Үйлдвэрлэлд нэвтрээгүй.										
11	<i>Гаргасан шийдэл</i>	Дулааны хоолойн зарчимд үндэслэсэн хөлдөөх тавцанг хөргөлтийн төхөөрөмжийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд ашиглах бүрэн бололцоотой болох нь туршилтаар батлагдсан.										
12	<i>Схем зураг</i>	 <p style="text-align: center;">Хөлдөөх тавцан</p>										

1	Бүтээлийн нэр	Бургасны хар мөөгний химийн найрлагын судалгаа
2	Сургуулийн нэр	Үйлдвэрлэлийн Технологийн Сургууль
3	Зохиогчдын нэр, утас	Батсүхийн Хулангоо /95198154/ Шагдарын Нарантуяа /88001236/
4	Бүтээлийн товч танилцуулга	Орон нутгийн ард түмэн бургасны хар мөөгийг модон дээрээ хатсан үед нь түүж савны өвчин, шүдний өвчин зэрэгт түгээмэл хэрэглэдэг учир уг мөөгний эмчилгээний шинж чанарыг тодорхойлох үүднээс химийн найрлага, биологийн идэвхит бодисыг судалсан болно.
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	Хүнс судлал, биологийн идэвхит нэгдлийн хими
6	Онцлог давуу тал	Урьд өмнө манай улсад энэ мөөгний химийн найрлагыг судалж байсан материал хомс байгаа учир энэ чиглэлийн судалгааг хийснээр уг мөөгний эмийн үйлдэлтний бодисуудыг илрүүлэн гаргахад энэхүү судалгааны давуу тал оршино.
7	Техник үзүүлэлт	
8	Үр дүн ба дүгнэлт	Ардын эмчилгээнд өвчин намдаах зорилгоор хэрэглэдэг бургасны хар мөөг нь 45.43% чийг, 54,5% хуурай бодис агуулж байна. Хуурай бодисын 7,5% нь уураг, 63% нь эслэг, 2,3% нь тос, 6,4 % нь эрдэс бодист ноогдож байна. Бургасны хар мөөгөнд нийт фенолт нэгдэл 5907,3 мкг/мл, флавоноид 82,39 мкг/мл хэмжээтэй агуулагдаж байгаа нь ижил төстэй зарим мөөгтэй харьцуулахад өндөр байна. Ийм учраас энэ мөөгний биологийн идэвхит бодисыг гүнзгийрүүлэн судалж, анагаах үйлчилгээг нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр батлах, мөн дагалдах ямар нэгэн хоруу бодис байгаа, эсэхийг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй гэж үзэж байна.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Үгүй
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Үгүй
11	Гаргасан шийдэл	Энэ мөөгний биологийн идэвхит бодисыг гүнзгийрүүлэн судалж, анагаах үйлчилгээг нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр батлах, мөн дагалдах ямар нэгэн хоруу бодис байгаа, эсэхийг гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид судалгаанд авсан мөөгний ангилал зүй, нэршлийг ШУА, Биологийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран тогтоох, бактерийн эсрэг үйлчлэлийг тодорхойлох, антиоксидант идэвхийг дахин тодорхойлох зорилт тавьж байна.
12	Схем зураг	


1	Бүтээлийн нэр	Навчит шанцай"-н (<i>lettuce - lactuca sativa l</i>) ургалтанд болон хөрсний үржил шимийг сайжруулахад бионүүрсний үзүүлэх нөлөө
2	Сургуулийн нэр	Хөдөө аж ахуйн их сургууль Мал аж ахуй биотехнологийн сургууль Бэлчээр тэжээллэг, химийн тэнхим
3	Зохиогчдын нэр, утас	С.сарантуяа химийн ухааны доктор (ph.d) 99183665 Ж.мөнгөнчимэг, хаабхт-ын оюутан, 99883510
4	Бүтээлийн товч танилцуулга	Бионүүрсийг гарган хөрсөнд нэмсэнээр хөрсний ашигтай бичил биетний тоо толгой өсөн үржих таатай нөхцөлийг бүрдүүлснээр хөрсний үржил шимийг нэмэгдүүлэн “навчит шанцай”-н (<i>lettuce - lactuca sativa l</i>) ургалтад нөлөөлөх байдлыг судлах
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	<ol style="list-style-type: none"> 1. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх 2. Хөрсний хүчиллэгийг саармагжуулах 3. Хөрсний ус чийг барих чадварыг дээшлүүлэх 4. Хөрсний микроорганизмын тоо толгойг нэмэгдүүлэх 5. Азотын ислийн ялгаралтыг бууруулах 6. Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах гэх мэт шинэ боломжийг бий болгосноор хүнсний чанар аюулгүй байдлыг шийдвэрлэх болон байгаль орчны асуудлыг шийдэхэд чухал ач холбогдолтой юм.
6	Онцлог давуу тал	Бионүүрсний адсорбцилох шинж чанар, микроорганизмыг идэвхжүүлэх шинж, хөрсний усыг бионүүрсний тусламжтай барин, механик бүтэц сайжирснаар хөрсний ашигтай бичил биетэнд амьдрах таатай орчин бүрдэн тоо толгой нь нэмэгдэж хөрсний органик нэгдлийн задрал түргэсч, ялзмагийн хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр хөрсийг ядуурлаас хамгаалж, ургамлын ургах таатай орчин бүрдэн, ургамлын ургалтыг түргэсгэх ач холбогдолтой юм.
7	Техник үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн түүхий эдээс tlud зууханд 600⁰с-д 80-86,6% с-ын агууламжтай бионүүрс гаргах • Бионүүрсний адсорбцилох чанар • Микроорганизмыг идэвхжүүлэх шинж • Хөрсний усыг бионүүрсний тусламжтай барих • Механик бүтэц сайжирснаар хөрсний ашигтай бичил биетэнд амьдрах таатай орчин бүрдэн тоо толгой нь нэмэгдэх • Хөрсний органик нэгдлийн задрал түргэсч • Ялзмагийн хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр хөрсийг ядуурлаас хамгаалж, ургамлын ургах таатай орчин бүрдэх
8	Үр дүн ба дүгнэлт	Төрөл бүрийн түүхий эдээс tlud зууханд 600 ⁰ с-д 80-86,6% с-ын агууламжтай бионүүрс гарган авлаа. Бионүүрсний адсорбцилох шинж чанар, микроорганизмыг идэвхжүүлэх шинж, хөрсний усыг бионүүрсний тусламжтай барин, механик бүтэц сайжирснаар хөрсний ашигтай бичил биетэнд амьдрах таатай орчин бүрдэн тоо толгой нь нэмэгдэж хөрсний органик нэгдлийн задрал түргэсч, ялзмагийн хэмжээ нэмэгдэн ургамлын ургах таатай орчин бүрдэнэ.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	-----
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Бионүүрсээ хөдөө аж ахуйд болон уурхайн нөхөн сэргээлтэнд хэрэглэж эхэлж байна.
11	Гаргасан шийдэл	Хью мак лахмины” аргаар мэдрэгдэх байдлыг шинжлэхэд уг бионүүрс нь хөрсөнд хэрэглэхэд тохиромжтой болох нь тогтоогдлоо.




Мод. хөрзөн, аргалаас үүсгэсэн биокарбонь спектр



ШУТИС-ийн Механик Тээврийн сургуулийн нисэх техникийн механикийн II курсын оюутан М.Баярсайхны Бүтээлийн танилцуулга

1	Бүтээлийн нэр	Mercedes benz G-Class
2	Сургуулийн нэр	Механик Тээврийн Сургууль
3	Зохиогчдын нэр, утас	Мягмаржав Баярсайхан 89899329
4	Бүтээлийн товч танилцуулга	<p>Mercedes-Benz G class машин нь хурд хүч , найдвартай байдал , тэнцвэрээ хадгалах чанараар дэлхийд алдартай машинуудын нэг билээ. Тиймээс ч бидний зохион бүтээсэн Mercedes Benz-G-Class автомашины дууриамал загварыг нь энэхүү шинж чанаруудыг хадгалж хийгдсэн.</p> <p>Бодит машиныг M1:14 харицаагаар масштаблан тооцоолж адил төстэйгээр хийх шаардлагтай учир доод эд анги, дугуй, кузов, шасси, явах эд анги болон нэмэлт тоноглолуудыг бүгдийг гараар хийж гүйцэтгэсэн дэлхийд ганц бүтээл юм.</p>
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	Техник Технолог сонирхдог инженер зохион бүтээгч нар. Инженерийн чиглэлийн хичээлийн сургалтанд.
6	Онцлог давуу тал	Хурд хүч сайтай
7	Техник үзүүлэлт	Дууриамал загвар, Mercedes Benz-G-Class Масштаб M1:14
8	Үр дүн ба дүгнэлт	ШУТИС-ийн оюутан залуусын дунд оюутны Клуб байгуулж инженерийн чиглэлийн хичээлүүдтэй уялдуулах сургалт явуулах боломжтой. Энэхүү автомашиныг хийх арга аргачлалыг зааж эзэмшүүлснээр чадварлаг уран гартай зохион бүтээгч инженер залуусыг өргөнөөр төрүүлэх боломжтой.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Үгүй
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Үгүй
11	Гаргасан шийдэл	Жинхэнэ автомашинд байдаг бүх тоноглол хийгдсэн. Хаалга цонх онгойно гэрэл чийдэн дохио асна.
12	Схем зураг	

1	Бүтээлийн нэр	Хананд авирагч робот.																		
2	Сургуулийн нэр	ШУТИС-МехТС																		
3	Зохиогчдын нэр, утас	Б. Баттөр, 99739482																		
4	Бүтээлийн товч	Энэхүү хананд авирагч робот нь барилгын тэгш гадаргуу болон шилэн хэсэг дээр																		
1	Бүтээлийн гэр	Бүтээлийн зориулалт: физик ололтийн өрсөлдөөн нэрлэгдэх дагшинг хөхөж) явдаг бөгөөд хөндлөн шилжилтийн хөдөлгүүр мөн босоо шилжилтийн хийн цилиндрийн тусламжтайгаар нэг хавтагай дээр хүссэн чиглэлдээ явах боломжтой бөгөөд өөр цонхруу шилжихэд зориулагдсан хүрээ давах механизмтай учир цонхны хүрээ болон бусад саадыг давж шилжиж чаддагаараа энэ төрлийн бусад роботуудаас давуу юмаа. Бидний бүтээсэн робот нь зөвхөн цонх угаадаг робот бус хананд авирдаг робот учир өөр зүйл гүйцэтгүүлэх боломжтой.																		
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	Шилэн фасадтай барилгын гадаргуйг цэвэрлэх, цонх цэвэрлэх, хананд авирдаг учир дээш юм зөөх, хүн явах боломжгүй хэсэгт явуулах.																		
6	Онцлог давуу тал	Хүрээ давах механизмтай																		
7	Техник үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th colspan="2">Роботын техникийн үзүүлэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Урт</td> <td>100см</td> </tr> <tr> <td>Өргөн</td> <td>105см</td> </tr> <tr> <td>Өндөр</td> <td>28см</td> </tr> <tr> <td>Жин</td> <td>11кг</td> </tr> <tr> <td>Алхах хурд</td> <td>1.36м/мин(max)</td> </tr> <tr> <td>Хөндлөн шилжих хурд</td> <td>0.2м/мин (±0,05м)</td> </tr> <tr> <td>Угаах хурд</td> <td>0.3x0.5м²/мин 1м²=2.5мин</td> </tr> <tr> <td>Даац</td> <td>0 - 15кг (max-30кг)</td> </tr> </tbody> </table>	Роботын техникийн үзүүлэлт		Урт	100см	Өргөн	105см	Өндөр	28см	Жин	11кг	Алхах хурд	1.36м/мин(max)	Хөндлөн шилжих хурд	0.2м/мин (±0,05м)	Угаах хурд	0.3x0.5м ² /мин 1м ² =2.5мин	Даац	0 - 15кг (max-30кг)
Роботын техникийн үзүүлэлт																				
Урт	100см																			
Өргөн	105см																			
Өндөр	28см																			
Жин	11кг																			
Алхах хурд	1.36м/мин(max)																			
Хөндлөн шилжих хурд	0.2м/мин (±0,05м)																			
Угаах хурд	0.3x0.5м ² /мин 1м ² =2.5мин																			
Даац	0 - 15кг (max-30кг)																			
8	Үр дүн ба дүгнэлт	Энэхүү роботын хувьд бусад энэ төрлийн роботууд болон цонх цэвэрлэгч роботуудаас хямд болсон. Хэрэв энэхүү хананд авирагч роботыг цонх цэвэрлэхэд ашиглавал цонх цэврэлдэг хүмүүсийг аюултай ажиллаас чөлөөлөхөөс гадна барилгын шилэн гадаргуйг хүнээр угаалгасанаас 2 дахин хямд болох ба хүний хөдөлмөрийг 90 хувиас илүү хөнгөвчилөх юм.																		
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Аваагүй																		
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Үйлдвэрлэлд нэвтрүүлэх бүрэн боломжтой.																		
11	Гаргасан шийдэл	Аалз шиг мөчтэй, наймаалж шиг сорох үйлдэл хийж хөдөлгөх сонголт хийсэн. Саадыг давахад хялбар болгохын тулд нэмэх тэмдэг бүхий хэлбэртэй байх нь тохиромжтой болохыг тогтоосон.																		
12	Схем зураг																			

		дүнгээс (Mill House ХХК-ын гурилын үйлдвэрийн жишээн дээр)
2	Сургуулийн нэр	ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургууль
3	Зохиогчдын нэр, утас	Э.Энхтуул, 89280023 Р.Цэрэндулам, М.Чанцалдулам, Н.Хэрлэн Удирдагч: Я.Алтанцэцэг, Ц.Минжмаа
4	Бүтээлийн товч танилцуулга	Манай улс жил бүр тодорхой хэмжээний буудай хураан авч тоон үзүүлэлтээр эх орны буудай, буудайн гурилын хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүрсэн боловч чанарын үзүүлэлт хурцаар яригдаж байна. Иймээс жил бүрийн шинэ ургацын буудай, түүний гурилын физик-технологийн шинж чанарыг судалж, үнэлгээ дүгнэлт гаргах шаардлагыг харгалзан 2014 оны шинэ ургацын зарим сортын буудай түүний гурилын физик-технологийн шинж чанарыг судалж үнэлгээ дүгнэлт өгөх зорилгоор энэхүү ажлыг гүйцэтгэв.
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	Хүнсний салбар, гурилын үйлдвэрүүд
6	Онцлог давуу тал	2014 онд Милл хаус ХХК-ын гурилын үйлдвэрт хүлээн авсан буудайн физик-технологийн шинж чанар ялангуяа гурил болох шинж чанарыг судалснаар боловсруулах технологийн горим үүнд тээрэмдэлтийн жор гаргах, ус дулаанаар боловсруулах, тээрэмдэлтийн бул хоорондох зайг тохируулах, улмаар үйлдвэрлэх гурилын нэр төрөл, гарцыг урьдчилан тогтоох боломж бүрдэнэ.
7	Техник үзүүлэлт	
8	Үр дүн ба дүгнэлт	Нийт 9 дээжнээс 4 дээж стандартын шаардлагыг хангахгүй байна. Ялангуяа Силос-1, Төв аймаг Замбалын сүлд буудайн гурилын дээж хүчиллэг, (0.1-0.2°Н-аар их), үнслэг (0.02-0.04%-иар их), цавуулаг 0.02% бага, Силос-1 дээжийн цавуулаг угаагдахгүй байсан тул хамгийн сул чанартай гэж тогтоов. Харин Өвөрхангай “Хархорин”, Угтаал “Вет прогресс” дээжүүд нь чанарын сайн үзүүлэлттэй, Буудайн гурил MNS244-2009 стандартын шаардлагыг хангаж байна.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	-
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Mill House ХХК-ын гурилын үйлдвэр үр дүнг ашиглаж байна
11	Гаргасан шийдэл	Уналтын тоон үзүүлэлт 7 дээжэнд шаардлага хангахгүй буюу амилаза ферментийн идэвх султай, харин 2 дээж нь амилаза ферментийн идэвх дунд зэргийн буюу талхны зориулалтаар ашиглах боломжтой байна. Силос-1, Төв аймгийн Замбалын сүлд буудайн гурилын чанар талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тохирохгүй сул чанартай байгаа тул тээрэмдэлтийн жор зохиож ашиглах шаардлагатай гэж дүгнэж байна.
12	Схем зураг	

1	Бүтээлийн нэр	Эгэл буржгарын (<i>Thalictrum simplex</i> L.) <i>in vitro</i> судалгаа
2	Сургуулийн нэр	ШУТИС, Үйлдвэрлэлийн технологийн сургууль
3	Зохиогчдын нэр, утас	Э.Соёлмаа , 88228862
4	Бүтээлийн товч танилцуулга	Өрнө, дорнын анагаах ухаанд эрт дээр үеэс өргөн хэрэглэгдэж ирсэн чухал ач холбогдол бүхий эмийн ургамал болох эгэл буржгарын бичил ургамал гарган авахын тулд үрийг эксплантаар сонгон авч гиббереллин (ГХ ₃) нэмсэн МС (Мурашиге, Скуг) тэжээлийн орчинд өсгөвөрлөхөд 36% соёолсон. Мөн үрийг тайван байдлаас гаргахын тулд устөрөгчийн хэт ислийн уусмалыг ашиглахад 0.1, 1%-ийн уусмалд соёололт нэмэгдэж 22.2-37,5% болов. Нахиа үүсэлт 0,25мг/л ТДЗ-тай тэжээлийн орчинд сайн байсан. Харин каллус үүсгэх зорилгоор үндэс, навч, үрийн талыг эксплантаар авч 2,4-дихлортфенокси цууны хүчил (2,4-Д)-ийг 6-бензиламинопурин (БАП) -тэй хоршуулан туршихад 4 долоо хоногийн дараа 1 мг/л 2,4-Д, 0,5 мг/л БАП-тай тэжээлийн орчинд үндэснээс каллус үүсэлт сайн байв.
5	Хэрэглээний хүрээ, зориулалт	Уг судалгааны ажлын үр дүнд улирлаас үл хамааран туршилт судалгаа явуулах дээж материалтай болохоос гадна эмчилгээний өндөр идэвхитэй зарим хоёрдогч метаболитийг судлах эх материал бий болгох боломжийг нээнэ.
6	Онцлог давуу тал	Энэхүү чухал эмийн ургамлын биохимийн шинжилгээ судалгааг нэлээд хийсэн байдаг боловч лабораторийн нөхцөлд хуруу шилэн дотор эдийн өсгөврийн аргаар ургуулж байгаагаараа Монголд анхдагч болсон.
7	Техник үзүүлэлт	
8	Үр дүн ба дүгнэлт	Эгэл буржгар (<i>Thalictrum simplex</i> L.)-ийг <i>in vitro</i> нөхцөлд өсгөвөрлөхөд үрийн соёололт ½МС тэжээлийн орчинд 30 хоногийн дараа 19%-тай байсан ба тэжээлийн орчинд гиббереллин нэмэхэд үрийн соёололт 36% болов. Үрийн соёолох чадварыг нэмэгдүүлэхийн тулд скарификаци хийхэд устөрөгчийн хэт ислийн 3 ба 5% уусмалд үр ургаагүй нь хэт өндөр концентрацид үр соёолох чадвараа алдсан байх магадлалтай. Харин 0.1 болон 1% уусмалд үрийн ургалт 22.2-37.5% болж нэмэгдэв. Ариун цухуйцаас эксплант сонгон авч нахиа үүсгэхэд 7 хоногийн дараа 2-р хувилбар буюу МС + 0,25 мг/л ТДЗ тэжээлийн орчинд нахиа үүсэх нь илүү байсан. Үндэс, навч, үрийн талаас эксплант сонгон авч 2.4-Д, БАП-ийг нэмсэн тэжээлийн орчинд каллус үүсгэхэд 3-р хувилбар буюу 1 мг/л 2.4-Д, 0.5 мг/л БАП тэжээлийн хувилбарт үндэснээс каллус үүсэлт сайн байв.
9	Патент зохиогчийн эрх авсан байдал	Аваагүй
10	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Үгүй
11	Гаргасан шийдэл	Эгэл буржгарын бичил ургамал болон каллусыг лабораторийн нөхцөлд амжилттай гаргасан ба уг судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай.
12	Схем зураг	